

УЛС ТӨРИЙН НАМУУДЫГ
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ НЬ:
САЙН ТАЛУУД НЬ ЮУ ВЭ?

ФЕРНАНДО КАСАЛ БЕРТОА

Удиртгал

Улс төрийн намуудыг төрөөс шууд санхүүжүүлэхийг¹ эсэргүүцэх хандлага нэлээд гарах боллоо. Саяхан гэхэд л (2017 оны Нэг сард) Итали улсад 43 жилийн турш төрөөс намуудад өгч ирсэн санхүүгийн дэмжлэгийг зогсоохоор шийдсэн байна. Үүний өмнө Польш (2015 оны 9 сар), Болгар (2016 оны 11 сард) төрөөс өгөх санхүүжилтыг зогсоох талаар ард нийтийн санал асуулга явуулсан боловч олигтой амжилт олоогүй юм.²

Европын бараг бүх л оронд³ улс төрийн намуудад сонгуулийн кампанит ажил, бусад үйл ажиллагаанд нь зориулж (40.9%) эсвэл зөвхөн бусад үйл ажиллагаанд нь зориулсан (47.7%) санхүүгийн дэмжлэгийг төрөөс олгож ирсэн боловч, төрөөс үзүүлдэг энэхүү санхүүжилтыг авлигыг өөгшүүлдэг, иргэдийн дунд үл итгэлцлийг⁴ бий болгодог, түүгээр ч үл барам намын улс төрийг “картел” хэв шинжтэй болгоход нөлөөлдөг хэмээн буруутгадаг (Katz and Mair, 2018). Харин улс төрийн намуудад төрөөс санхүүжилт олгохын үндсэн санаа нь сонгогчдын хүсэл сонирхлыг үл ойшоон, ашиг сонирхлоо хамгаалж, төрийг “саах” гэсэн хувийн компаниудын нэгдэл шиг бус, харин “ус, цахилгаан зэрэг нийтийн ахуйн үйлчилгээ” үзүүлдэг байгууллага шиг нийтийн сонирхлын төлөө ажилладаг (Biezen, 2004), болгоход чиглэж байгаа юм.

Гэвч бодит байдал үнэнээс хол зөрүүтэй байна. Судалгааны бүтээлүүдээс үзэхэд зөв зохицуулалттай, улсын санхүүжилт нь улс төрийн намуудыг илүү хариуцлагатай, тогтвортой болгохоос гадна урт хугацаандаа намын тогтолцоог тогтвортой болгож, сонгуулийн үеийн туйлшрал болон улс төрийн авлигыг бууруулж, ардчилал бодитойгоор хэрэгжихэд эерэг үр нөлөөтэй аж. Эдгээр эерэг нөлөөг тус бүрт нь авч үзэцгээе.

1 Төрөөс үзүүлэх шууд бус санхүүжилтэд хэвлэл мэдээллийн цаг, зай өгөх, татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг ордог.

2 Уг санал ард нийтийн санал асуулгаар дэмжигдсэн (тус бүртээ 82.6% болон 74%-ийн дэмжлэг авсан) боловч, уг санал асуулга хүчин төгөлдөр болох шаардлагатай ирц хүрээгүй тул (50-аас дээш хувьд хүрээгүй) хууль болон батлагдаагүй.

3 Беларусь, Итали, Мальт, Монако, Ватикан, Швейцарьт л байдаггүй.

4 Дэлхийн бараг тэн хагаст нь улс төрийн намыг хамгийн их авлигажсан байгууллага гэж үзэж байна. (Global Corruption Barometer, 2013 үзнэ үү). Монголын хувьд ч мөн нөхцөл байдал ижил байна. (Asia Foundation, 2019 үзнэ үү).

1. НАМЫН ТОГТОЛЦООНЫ ТОГТВОРЖИЛТ

Намын тогтолцооны тогтвортой байдал нь ардчилал тогтвортой хадгалагдах (Casal Bértoa, 2017a) болон улам бэхжихэд (Mainwaring, 1999) амин чухал үүрэгтэй гэж тооцогддог. Энэ нь Монгол шиг шинэ тутам ардчилсан орны хувьд нэн чухал ач холбогдолтой юм. Учир нь хэдий Төв болон Зүүн Азид, коммунист дэглэмээс бүрэн ардчилагдсан ганц улс боловч, намын институтчлэлийн түвшин сул (Жаргалсайхан, Мөнхбат нар, 2019 он; КАС, 2019), бодлого, мөрийн хөтөлбөрт суурилсан гэхээсээ илүү клиентелист намын тогтолцоотой (Bonilla and Shagdar, 2018), иймээс патронаж (эзэн, даргын ивээлийн бүлэгт багтах, даалгавар биелүүлэх харилцаа) болон авлигын өндөр түвшинтэй (Radchenko and Jargalsaikhan, 2017; Singer, 2009) болж байгаа шинж ажиглагдаж байна.

Харин судалгаанаас үзэхэд намын тогтолцоог тогворжуулагч хүчин зүйлсийн нэг бол төрөөс өгөх санхүүжилт гэдэг нь илэрхий байдаг. Юуны өмнө, Бирнир (2005)-ийн тогтоосноор улсаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг нь намын сонгогчдын бүлгийг урт хугацаанд тогтвортой байхад нөлөөлдөг байна. Учир нь (1) улс төрийн намуудад талархан дэмжигчдээ хамруулсан арга хэмжээ зохион байгуулахад шаардлагатай нөөцийг өгч, намууд дэмжигчидтэйгээ (гишүүд, сонгогчид болон бусад дэмжигчид) байнгын, тасралтгүй харилцаа холбоотой байхаас гадна, (2) урт хугацаандаа улс төрийн хүчирхэг, мэргэжлийн зохион байгуулалттай байх чадварыг бэхжүүлэх замаар төрөөс олгох санхүүжилт нь сонгогчдын намын дэмжлэг, сонголтыг нэмэгдүүлж, сонгуулийн үеийн сонголтыг илүү тодорхой, тогтвортой болгодог. Ингэснээр, улс төрийн намуудын нийгмийн суурь, легитим чанар хоёрыг бэхжүүлэхээс гадна, ардчилсан үйл явц нь төлөөллийн, хариуцан тайлагнах тогтолцоо гэдэгт иргэдийн итгэх итгэлийг бататгаж өгдөг (Lane and Ersson, 2007).

Мөн түүнчлэн, улс төрийн намуудад улсаас санхүүжилт авах эрхийг баталгаажуулах нь шинэ улс төрийн хүчнүүд гарахаас сэргийлэх нөлөөтэй (Spirova, 2007; Potter and Tavits, 2015) бөгөөд үр дүнд нь намуудын тоог бууруулж (Booth and Robbins, 2010), намын тогтолцоог илүү ойлгомжтой, тодорхой (сонгогчдын хувьд), удирдан чиглүүлэхэд хялбар (элитүүдийн хувьд)⁵ болгодог. Төрийн санхүүжилт байхгүй газар чинээлэг ивээн тэтгэгчтэй намууд ямар ч хязгаарлалтгүйгээр олноор гарч ирж болзошгүй тул төрөөс санхүүжилт өгдөг газар сонгуулийн болон санхүүгийн хувьд чадамжтай намууд л тэсч үлдэх, боломжтой байх юм. Иймээс намуудын тоо тогтмолжих, эвслүүд болон засгийн газрууд тогтвортой удаан хугацаанд ажиллах боломж бүрдэнэ.

Гуравт, дээр дурдсан шалтгааны учраас, төрийн санхүүжилт нь намуудын хоорондын харилцааг (өөрөөр хэлбэл, хамтран ажиллах, зөвшилцөх, хорших гэх мэт) тогтмолжиж,

⁵ Ялангуяа Монгол лугаа улсуудын хувьд (өнгөрсөн 6-р сард болсон УИХ-ын сонгуулийн үеэр 17 нам, эвслээс нэр дэвшигчдийн жагсаалт оруулж ирсэн), сонгуулийн үеийн маш олон намууд, нэр дэвшигчдийн тоог цаашид бууруулах санал жин дарж байгаа юм.

тодорхой хэв төлөвтэй болоход нөлөөлдөг. Энд дурдсан болон бусад судалгаанаас дүгнэхэд, төрөөс олгох санхүүжилт нь сонгуулийн тогтвортой байдлыг дэмжиж, намуудын хоорондын хүчний тэнцвэрийг хадгалж, парламент дахь ихээхэн савалгаатай өөрчлөлтийг саармагжуулах (өөрөөр хэлбэл, хууль тогтоох байгууллагад суудал авч "орж ирэх" болон ялагдал хүлээж "гардаг" намын тоо цөөхөн) замаар засгийн эрхэнд илүү давамгайл байдлаар, тогтсон горимын дагуу ээлжлэн гардаг тогтвортой засгийн газар бүхий, олонд танигдсан болон үзэл суртлын хувьд ойлгомжтой намуудын өрсөлдөөнийн хэв маягийг төлөвшүүлдэг юм (Casal Bertoa, 2017b).

Дээр дурдсан голлох гурван судалгаа нь "хамгийн төсөөтэй орнуудын харьцуулалт"-ын аргыг ашиглан Зүүн Европын орнууд болон хуучин Зөвлөлтийн орнуудыг авч үзсэн бол, Африк (Sanches, 2018), Латин Америк (Bruhm, 2017) зэрэг бусад бүс нутагт хийсэн судалгаагаар ч гэсэн улс төрийн намуудад төрөөс олгодог санхүүгийн дэмжлэг нь намын тогтолцооны тогтвортой байдалд эерэгээр нөлөөлдөг болох нь тогтоогдсон юм.

2. УЛС ТӨРИЙН НАМУУД

Улс төрийн намуудад төрөөс санхүүжилт өгөх нь намуудыг урьдчилан харах боломжтойгоор үйл ажиллагаа явуулах, өрсөлдөх, системийн түвшинд тогтвортой байдлыг сайжруулахын зэрэгцээ, намууд тэсч үлдэх болон институтжилт өндөртэй байгууллага болон төлөвшихөд чухал хувь нэмэртэй байна.

Тэсч үлдэхүй


Төрөөс үзүүлэх санхүүжилт нь тодорхой тооны улс төрийн намууд тогтон бэхжихэд шаардлагатай санхүүгийн нөөцийг хангахаас гадна, ийм боломж байгаа гэдэг нь л намуудын хувьд бэрхшээлийг даван туулах, тэсч үлдэх шийдвэр гаргахад нөлөөлдөг (Spirova, 2007; Bolleyer, 2013; Casal Bértoa and Taleski, 2016; Casal Bértoa and Walecki, 2018). Коммунист дэглэмээс ардчилалд шилжсэн Европын 14 орны улс төрийн намын санхүүжилтын өөрчлөлтийг судалж үзээд, Касал Бертоа, Спирова (2019) нар улсаас санхүүжилт авдаг улс төрийн намууд нь ийм санхүүжилт авдаггүй намуудтай харьцуулахад тэсч үлдэх магадлал өндөр байна (тус тус нь 92% болон 50%-тай байна) гэж дүгнэжээ.

Түүгээр ч зогсохгүй, илүү сонирхол татаж байгаа зүйл бол төрийн санхүүжилт авах боломж нь сонгуулийн босго давж, парламентад суудал аваагүй боловч "төрийн санхүүжилт авах босго"⁶ давах хэмжээнд хүртэл сонгогчдын хангалттай хувийн саналыг татаж чадсан намуудад онцгой ач холбогдолтой болох нь харагдаж байгаа юм. Доорх бүдүүвчид (Бүдүүвч 1.) парламентад суудалгүй боловч төрөөс санхүүжилт авдаг болон авдаггүй намуудын тэсч үлдэх түвшинг харьцуулан харуулав. Зөвхөн ганц тохиолдлоос (Румынь) бусад бүх орнуудад төрөөс санхүүжилт авдаггүй намуудтай харьцуулахад, төрийн санхүүжилттэй намуудын, оршин тэсч үлдэх боломж нь маш өндөр байгааг харуулж байна. Парламентад суудалгүй намуудын хувьд улсаас санхүүгийн дэмжлэг авдаг намуудын оршин үлдэх магадлалын ялгаа нь санхүүжилт авдаггүй намуудаас дундажаар хоёр дахин илүү байна (тус бүр нь 73% ба 36%)⁷.

6 Өөрөөр хэлбэл, төрөөс татаас авах эрх үүсэхэд шаардлагатай саналын хувь юм.

7 Сонирхолтой нь парламентад суудалгүй намуудад төрийн санхүүжилт өгдөггүй орнуудын хувьд, энэ ялгаа нь дундажаар харьцангуй бага байгаа нь сонирхол татаж байна (тус бүр нь 93.1% болон 58.7%-тай байна).

Бүдүүвч 1. Босго (сонгуулийн болон санхүүжилт авах) хооронд байгаа улс төрийн намуудын тэсч үлдэх түвшин (хувиар үзүүлэв)



Эх сурвалж: Касал Бертоа, Спинова нар (2019: 239)

Эндээс үзэхэд парламентад суудал авч чадаагүй боловч сонгогчдын “нэлээд жинтэй” дэмжлэг авсан улс төрийн намуудад төрөөс санхүүжилт олгох хэрэгцээ байгааг тодорхой харуулж байна. Ингэснээр намын тогтолцоон дахь нам солигдох өөрчлөгдөх үйл явцыг удаашруулж, намын тогтолцооны тогтвортой байдалд эерэгээр нөлөөлөхийн (дээрхийг харна уу) сацуу сонгогчдын нэлээд хэсэг нь парламентын гадуур үзэл бодлоо илэрхийлэх боломжтой болсноор төлөөллийн чадварыг нь нэмэгдүүлж байгаа юм.

Институтжилт

Мөн төрөөс олгох санхүүгийн дэмжлэг нь улс төрийн намууд мэргэжлийн, чадварлаг намын байгууллагыг бүрдүүлэх, тэдгээрийн институтжилтэд нь нэмэртэй бөгөөд ялангуяа шинэ тутам ардчилсан орнуудад ардчилал амжилттай хэрэгжихэд эерэг нөлөөтэй (Tavits, 2013 үзнэ үү). Энэ нөхцөлд улсаас үзүүлэх санхүүжилт нь намуудыг томоохон хандивлагчдаас санхүүгийн хувьд бие даасан байх боломжийг бүрдүүлэхээс гадна, улс орны нутаг дэвсгэрт бүхэлд нь сайн боловсон хүчин, чадамж сайтай байгууллагыг төлөвшүүлэх нөхцлийг бий болгоно⁸.

Гэхдээ, төрөөс олгодог санхүүжилт нь намуудад гишүүдийн хүрээгээ өргөтгөх, дэмжигчдийг татахад шууд нөлөөлдөггүй, учир нь энэ нь намууд иргэдийн дэмжлэгийг авах бодлого, мөрийн хөтөлбөр боловсруулж, танилцуулах намуудын чадавхиас илүү

⁸ Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээ болон намууд өдөр тутмын үйл ажиллагаандаа чинээлэг нэр дэвшигчдийн тусламжинд найддаг өнөөгийн хандлагыг харгалзаж үзвэл (Uribe Burcher and Casal Bértoa, 2018), энэ нь бүр нэн чухал ач холбогдолтой.

хамаардаг⁹. Харин энэхүү санхүүгийн дэмжлэгийн үр нөлөөгөөр намын удирдлага “намын албан хаагчидтай хамтран гишүүд, дэмжигчдийг намын дүрэм журамд нэгтгэн зохион байгуулах, стандарт үйл ажиллагаагаа сайжруулан, хэвшүүлэх, тогтсон дэд бүтцийг байгуулах” болон үр дүнд нь сонгуулийн хариуцан тайлагналыг сайжруулах боломжтой юм (Bolleyer and Ruth, 2018: 291). Түүнчлэн, намын шийдвэр гаргах үйл явцыг илүү системтэй, горимд оруулснаар, төрийн санхүүжилт нь намын эрх мэдлийн төвийг төрийн албанд байгаа албан тушаалтнуудаас намын төв байгууллага руу шилжүүлж, намын бодлогод голлох бие хүмүүсээс илүү үзэл суртлыг тэргүүн эгнээнд гаргаж ирэх ач холбогдолтой.

9 Төрийн татаас нь тоглоомын талбарыг тэнцвэржүүлэхэд чухал нөлөөтэй боловч, сонгуулийн өрсөлдөөнд хэн ялах нь бусад хүчин зүйлээс (заавал санхүүгийн байх албагүй) бас хамаардаг (Bolleyer, 2013).

3. ТУЙЛШРАЛ


Улс төрийн намд олгох төрийн санхүүжилт нь ардчилалд сайнаар нөлөөлж буй гурав дахь хэлбэр нь үзэл суртлын туйлшралын түвшинг бууруулдаг. Учир нь тогтолцооны эсрэг чиглэсэн, улс төрийн спектрийн туйлд байршдаг, хувийн санхүүжилттэй (олигархууд болон тодорхой нэг асуудлаар ивээн тэтгэлэг үзүүлдэг) намуудаас ялгаатай нь төрийн санхүүжилттэй намууд нь гол төлөв ихэнх сонгогчид (тэд мөн аядуу, төвч байр суурьтай) төвлөрдөг улс төрийн үзэл бодлын төвд байршдаг. Тийнхүү, намуудыг илүү олон сонгогчдыг татахад нөлөөлснөөр төрийн санхүүжилт нь туйлшралын түвшинг бууруулдаг бөгөөд намуудын үзэл суртлын заагийг бууруулж алсдаа зөвшилцөлд хүрэх боломжийг бүрдүүлж байгаа юм. Үүний үр дүнд тогтолцооны эсрэг шинжтэй намуудын сонгуулийн дэмжлэг багасахаас гадна, тогтолцооны намуудын талаарх сэтгэл ханамжийн түвшин өсөх юм.

Тогтолцооны эсрэг намуудын сонгуулийн дэмжлэгт төрийн санхүүжилтын үзүүлэх нөлөөллийг 1990-2017 оны Зүүн Европын орнуудын жишээн дээр саяхан хийсэн судалгаандаа Касал Бертоа, Рама (2019) нар ийм үр дүнг тогтоосон юм. Төрийн санхүүжилт дутагдалтай орнуудад иймэрхүү тогтолцооны-эсрэг намуудын сонгогчдын дэмжлэг, төрийн санхүүжилт бүхий орнуудыг бодвол илүү өндөр байна. Төрөөс санхүүжилт олгох шаардлага зөөлөн байх тусам (санхүүжилтэд хамрагдах босго доогуур байх гэх мэт), эдгээр намууд сонгогчдын дэмжлэг муутай байгаа нь улс төрийн намыг төрөөс санхүүжүүлэхдээ харьцангуй зөөлөн шаардлага, болзол тавих хэрэгтэйг харуулж байгаа юм.

4. ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ БАЙДАЛ

Төрөөс өгөх санхүүжилт нь ардчиллын чанарыг өсгөж буй бас нэг хэлбэр нь намын хариу үйлдэл үзүүлэх байдал юм, өөрөөр хэлбэл намууд төрийн санхүүжилт авах хувь нь өсөх хэрээр намууд иргэдийн шаардлага, сонирхолд улам идэвхтэй хариу үйлдэл үзүүлдэг байна. Дараах бүдүүвчид (Бүдүүвч 2) төрийн санхүүжилт болон үр нөлөө гэж ойлгогддог хариу үйлдэл үзүүлэх түвшингийн хоёр хэмжүүрийн харилцан нөлөөллийг авч үзсэн бөгөөд тухайн улсын намууд төрийн санхүүжилт авч буй хэмжээ нь “сонгогчид хэний төлөө санал өгсөн болон эрх мэдэлд хэн байгааг чухал гэж сонгогчид итгэж байгаа” түвшинтэй эерэг хамааралтай байна (Costa Lobo and Razzuoli, 2017: 119).¹⁰ Өөрөөр хэлбэл, төрийн санхүүжилт нь хариу үйлдэл үзүүлэх болон улс төрийн үр нөлөөгөөрөө нам болон тэдний сонгогчдын хооронд зай ялгаа үүсгэхгүй байна.

Бүдүүвч 2. Төрийн татаас ба үр нөлөөний талаарх төсөөллийн хувь



Эх сурвалж: Costa Lobo and Razzuoli (2017: 117)


10 Намын түвшинд ч ойролцоо дүнг харж болно (Costa Lobo and Razzuoli, 2017: 118-г үзнэ үү).

5. АВЛИГА

Бас нэг эерэг нөлөөлөл бол судлаачид болон улс төрийн зүтгэлтнүүдийн үзэж буйгаар улс төрийн намд олгох төрийн санхүүжилт нь авлигыг бууруулахад нөлөөлдөг аж. Учир нь төрийн мөнгийг хянахад хялбар байхаас гадна, хувийн санхүүжилтыг тэр дундаа хууль бус эх сурвалжтай санхүүжилтыг хэрэгцээгүй болгож байгаа юм. (Nassmacher, 2001; Roper, 2008). Доорх бүдүүвчид (Бүдүүвч 3) төрийн санхүүжилт болон авлигын хоорондын хамаарлыг авч үзэв. Ялангуяа Европт төрөөс олгох кампанит ажлын санхүүжилт нь авлигын түвшин доогуур байхад нөлөөтэй байна. Тухайлбал, “эдүгээ авлигын түвшин доогуур илүү олон орнуудад төрөөс сонгуулийн кампанит ажлын санхүүжилт олгодог” нь тодорхой байна (IDEA, 2017: 132).

Хаммэл тэргүүтэй судлаачид (2018) улс төрийн санхүүжилтын зохицуулалт болон 154 улс дахь 112 жилийн авлигын түвшингийн хоорондын хамаарлыг судалсны үндсэн дээр “санхүүгийн дэмжлэг нь хээл хахууль, шамшигдуулалтыг шахах замаар авлигыг бууруулж, даган гарах санхүүжилтын зохицуулалт нь уг хэрэг илэрвэл авах хуулийн болон нийгмийн арга хэмжээг чангатгадаг” (2018: 22).

Бүдүүвч 3. Дурдагдсан онуудын төрөөс олгох кампанит ажлын санхүүжилт ба авлигын доод түвшин



Эх сурвалж: IDEA (2017: 132)

Гэвч ийнхүү авлигыг хянах нь төрийн санхүүжилт байхаас гагцхүү хамаарахгүй бөгөөд харин төрийн санхүүжилтын дэглэмээс голлон шалтгаалах юм. Ийнхүү, мөн өөр судалгаанд ажиглагдсанаар (Casal Bértoa болон бусад, 2014), нэлээд хязгаарлалт ихтэй болон улс төрийн нам нь төрийн санхүүжилтээс онцгой хамааралтай улсуудад төрийн санхүүгжийн дэмжлэг нь авлигыг бууруулахад нөлөөлж чадахгүй байгаа юм. Эдгээр тохиолдолд, улс төрийн намууд нь сонгогчдын сонирхлыг үл ойшоож, төрийн нөөцийг

ашиглах сонирхолтой намуудын явцуу сонирхол давамгайлахын сацуу, намын авлигын төсөөллийн түвшин өсөх хандлагатай нь тогтоогдсон (мөн тэнд, 2014: 367).

Харин ямар ч тохиолдолд төрийн санхүүжилттэй үед төрийн холбогдох байгууллагаас хяналт, шалгалт хийх боломжийг хялбар болгож улс төрийн намуудын санхүүжилтийг ил тод болгож өгдөг. Ийм нөхцөлд төрийн санхүүжилтын харьцангуй “өгөөмөр” (хэмжээний болон хүлээн авагчид тооцох шалгуурын хувьд) дэглэм тогтоож, хувийн санхүүжилтэд хязгаарлалт тавьж, зохих эрх мэдлийг нь нарийвчлан зааж өгсөн (мөрдөн шалгах болон хариуцлага тооцох), үйл ажиллагаа нь уялдаатай явагдах, хангалттай нөөц, хүч бүхий (мэргэжлийн боловсон хүчин гэх мэт) хяналтын хараат бус байгууллагатай байх нь зүйтэй (Uribe Burcher and Casal Bértoa, 2018).

Төрийн санхүүжилт нь хувийн санхүүжилтын эх сурвалжаас санхүүгийн хамааралтай байдлын эсрэг эсвэл зүй бус мөнгө босгох үйл ажиллагааны эсрэг шидэт ерөндөг, цор ганц шийдэл биш юм (Casas-Zamora, 2005: 39). Хэдий тийм боловч төрийн санхүүгийн дэмжлэгийг зохистой зохицуулалтын хамт шийдэж чадвал, муугаасаа илүү сайн үр нөлөөтэй. Энэхүү өгүүлээс урган гарах гол дүгнэлт бол төрийн татаас нь ардчиллын хэрэгжилтэд дараах эерэг үр нөлөөтэй байна. Үүнд, 1) энэ нь намын тогтолцоог тогтворжуулдаг, 2) намууд удаан оршин тогтнох болон институтжихэд нөлөөлдөг, 3) үзэл суртлын туйлшралыг саармагжуулдаг, 4) улс төрийн хариу үйлдэл хийх чадварт нөлөөлдөг, 5) авлигатай тэмцэхэд нэмэртэй байдаг байна. Учир нь төрийн татаасын арга хэмжээг нэвтрүүлэхэд дангаараа бус түүнийг дагасан эрх зүйн зохицуулалт хийдэг (хандивын илүү өндөр хязгаар болон хориг, чангаруулсан хяналт, илүү хатуу хариуцлагын арга хэмжээг тусгадаг). Эдгээр үндэслэл болон дээр дурдсан судалгааны дүнд үндэслэн дараах санал зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

1. Сонгуулийн болон бусад үйл ажиллагааны зориулалтаар улс төрийн намуудад өгөх төрийн санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх. Гэхдээ улс төрийн намуудын хувийн санхүүжилтыг ор тас хориглоно гэсэн үг биш. Харин ч төрийн болон хувийн санхүүжилтыг хослуулсан дэглэм байвал зохилтой¹¹.
2. Аль ч тохиолдолд, төрийн санхүүжилтын харьцангуй “зөөлөн” (мэдээж зохих түвшинд) дэглэмийг нэвтрүүлж, бүхий л “нөлөө бүхий” намуудыг (сонгуульд нийт саналын 2 доошгүй хувийн санал авсан намууд) хамруулах.
3. Төрийн санхүүжилтыг хуваарилдаг шалгуурыг парламент дахь тухайн намын эзэлж буй суудлын хувь хэмжээнээс илүү сонгогчдын нийт саналын авсан хувьд нь нийцүүлэн тооцох нь зүйтэй.
4. Мөн “дүйцүүлэх санхүүжилт”-ын тогтолцоог нэвтрүүлж, зөвхөн төрөөс хамааралтай байх бус харин ч төрийн санхүүжилтын хэмжээг тухайн намын хувийн санхүүжилт босгох чадвартай нь уялдуулан тооцдог зарчим юм.¹²
5. Түүнчлэн төрөөс олгох татаасын тодорхой хувийг улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих (жишээ нь 20 хувийг) болон улс төрийн мэдлэг олгох, сургалтын үйл ажиллагаа явуулахад (жишээ нь 10 хувийг) зарцуулахаар зааж өгч болно.

¹¹ Харин хувь хүмүүсийн хандивын дээд хэмжээг нэмэгдүүлж, үүний эсрэгээр компаниудын хандивын хэмжээг алсдаа цуцлах нь зүйтэй юм. (Uribe Brucher and Casal Bértoa, 2018: 26).

¹² Энэхүү тогтолцоо нь намууд хувь хүмүүс, гишүүдээс босгож чадах хандивтай нь төрийн татаасыг тэнцүүлэн дүйцүүлж олгох болзолтой. Германд намууд орлогынхоо тал хувийг хувийн эх сурвалжаас босгох ёстой бөгөөд төрийн санхүүжилтыг хамгийн сүүлд болсон сонгуулиар авсан санал бүрт нэг ижил үнэлгээгээр тооцож олгодог байна. Харин энэхүү дүндээ, бусад эх сурвалжаас олсон евро бүрийг 0.45 еврогоор тооцож төрөөс нэмж олгох (хууль ёсоор олсон хандив, гишүүнчлэлийн хураамж, сонгуульт албан тушаалтнаас авсан хандив зэрэг болно) бөгөөд энэ нь нэг хандивлагчийн хувьд 3,300 евро хүртэл байна. Үүнээс ялгаатай нь Нидерландад нэгдсэн нэг татаас өгөхөөс гадна, намын хууль тогтоох байгууллага дахь төлөөллийг харгалзан нэг дүн, мөн 1,000 аас доошгүй гишүүнтэй (нийт татаасын 11.5% болдог) намуудад (гишүүдийн тоонд нь хувь тэнцүүлэн) олгодог байна.

6. Тайлагналын зохих тогтолцоо бүрдүүлж, төрийн санхүүжилтээр хийсэн гүйлгээ, худалдан авалт бүрийг бүртгэлжүүлэх шаардлагатай.¹³
7. Намын санхүүг удирдан, зохицуулдаг албан тушаалтнуудад хариуцлага, шаардлагатай тохиолдолд, эрүүгийн хариуцлагын арга хэмжээг нарийвчлан зааж өгөх (жишээлбэл, намын санхүүч, нягтлан бодогч) зэрэг болно.

¹³ Хамгийн сайн хувилбар иймэрхүү гүйлгээний мэдээг аль болох шуурхай цахимаар мэдээлэхээр шийдэх хэрэгтэй.

- Asia Foundation (2019): *Survey on Perceptions and Knowledge of Corruption*. Available at <http://khamtdaa.mn/survey-on-perceptions-and-knowledge-of-corruption-2019/>. Accessed on October 8th, 2020.
- Biezen, I. van (2004): Political parties as public utilities. *Party Politics*, v. 10, n. 6, pp. 701–722
- Birnir, J. K. (2005). "Public Venture Capital and Party Institutionalization." *Comparative Political Studies*, v. 38, n. 8, pp. 915–938
- Bolleyer, N. (2013) *New Parties in Old Party Systems: Persistence and Decline in Seventeen Democracies*. Oxford: Oxford University Press
- Bolleyer, N. and Ruth, S. (2018): "Elite Investments in Party Institutionalization in New Democracies: A Two-Dimensional Approach", *Journal of Politics*, v. 80, n. 1, pp. 288–302
- Bonilla, L. and Shagdar, T. (2018): "Electoral Gifting and Personal Politics in Mongolia's Parliamentary Election Season", *Central Asian Survey*, v. 37, n. 3, pp. 457–474
- Booth, E. and Robbins, J. (2010). Assessing the Impact of Campaign Finance on Party System Institutionalization. *Party Politics*, v.16, n. 5, pp. 629–650
- Bruhn, K. (2017): "Money for Nothing? Public Financing and Party Building in Latin America", in Steven Levitsky, James Loxton, Brandon van Dyck and Jorge I. Domínguez (eds.) *Challenges of Party-Building in Latin America*. New York: Cambridge University Press
- Casal Bértoa, F. (2017a): "Political Parties or Party Systems? Assessing the 'Myth' of Institutionalization and Democracy", *West European Politics*, v. 40, n. 2, pp. 402–429
- Casal Bértoa, F. (2017b). It's Mostly about Money! A Multi-method Research Approach to the Sources of Institutionalisation. *Sociological Methods and Research*, v. 46, n. 4, pp. 683–714
- Casal Bértoa, F. and Spirova. M. (2019). Parties between Thresholds: State Subsidies and Party Behavior in Post-communist Democracies, *Party Politics*, v. 25, n. 3, pp. 233–244
- Casal Bértoa, F. and Rama, J. (2019): "The Two Faces of Janus: On the Determinants of Anti-establishment Parties' Success in Post-communist Europe in Comparative Perspective", Paper presented at the Political Studies Association (PSA) Annual Conference (Nottingham, April 15–17)
- Casal Bértoa, F. and Walecki, M. (2018): "Party Regulation and the Reshaping of Party Politics in Poland", in Fernando Casal Bértoa and Ingrid van Biezen (eds.) *The Regulation of Post-communist Party Politics*. Abingdon and New York: Routledge
- Casal Bértoa, F. and Taleski, D. (2016): Regulating Party Politics in the Western Balkans: The Legal Sources of Party System Development in Macedonia. *Democratization*, v. 23, n. 3, pp. 545–567
- Casal Bértoa, F., Molenaar, F., Piccio, D. R. and Rashkova, E. R. (2014). The World Upside Down: De-legitimising Political Finance Regulation. *International Political Science Review*, v. 35, n. 3, pp. 355–376
- Casas-Zamora, Kevin (2006): *Paying for democracy: political finance and State funding for parties*. Colchester, ECPR Press

- Costa Lobo, M. and Razzuoli, I. (2017): "Party Finance and Perceived Party Responsiveness", in Susan E. Scarrow, Paul D. Webb and Thomas Poguntke (eds.) *Organizing Political Parties: Representation, Participation and Power*. Oxford: Oxford University Press
- Global Corruption Barometer (2013): Accessible at <http://www.transparency.org/gcb2013/results>
- Hummel, C., Gerring, J. and Burt, T. (2018): "Do Political Finance Laws Reduce Corruption?". *V-Dem Working Series*, n. 60
- IDEA, International (2017): "Money, Influence, Corruption and Capture: Can Democracy Be Protected?", in *The Global State of Democracy: Exploring Democracy's Resilience*. Stockholm: International IDEA. Available at: <https://www.idea.int/gsod/files/IDEA-GSOD-2017-REPORT-EN.pdf>
- Jargalsaikhan, A. and Munkhbat, A. (2019): *The Internal Democracy Index of Mongolian Political Parties*. Ulaanbaatar: DeFacto Institute. Available at <file:///Users/saintmoro/Downloads/The-Internal-Democracy-Index-of-Mongolian-Political-Parties-2019.pdf>. Accessed on October 7th, 2020
- KAS (2019): *Politbarometer*. Available at <https://www.kas.de/documents/268650/268699/Politbarometer+Mongolisch+und+Englisch.pdf/95f32c70-1543-8809-a05e-8b863ee73bbd?version=1.0&t=1555656595941>. Accessed on October 9th, 2020
- Katz, Richard S. y Mair, Peter (2018): *Democracy and the Cartelization of Political Parties*. Oxford: Oxford University Press
- Lane, J-E. and Ersson, S. (2007): "Party System Instability in Europe: Persistent Differences in Volatility between West and East?", *Democratization*, v. 14, n. 1, pp. 92-110
- Mainwaring, S. (1999): *Rethinking Party Systems in the Third Wave of Democratization: The Case of Brazil*, Stanford, CA: Stanford University Press
- Nassmacher, K-H. (2001): "Comparative political finance in established democracies", in Karl-Heinz Nassmacher (ed.) *Foundations for Democracy: Approaches to Comparative Political Finance*. Baden-Baden: Nomos Verlag
- Potter, J. and Tavits, M. (2015): "The Impact of Campaign Finance Laws on Party Competition", *British Journal of Political Science*, v. 45, n. 1, pp. 73-95
- Radchenko, S. and Jargalsaikhan, M. (2017): "Mongolia in the 2016-17 Electoral Cycle: The Blessings of Patronage", *Asian Survey*, V. 57, N. 6, PP. 1032-1057.
- Roper, S.D. (2008): "Introduction: The influence of public finance on post-communist party systems", in Steven D. Roper and Janis Ikstens (eds.) *Public Finance and Post-communist Party Development*. Aldershot: Ashgate
- Sanches, E. (2018): *Party Systems in Young Democracies: Varieties of Institutionalization in Sub-Saharan Africa*. New York: Routledge
- Singer, MM. (2009): "Voters with dirty money: The relationship between clientelism and corruption", *Paper presented at the American Political Science Association Annual Confer-*

ence (Toronto, September)

Spirova, M. (2007). *Political Parties in Post-communist Societies*. New York: Palgrave Macmillan

Uribe Burcher, C. and Casal Bértoa, F. (2018): *Political Finance in Mongolia: Assessment and Recommendations*. Stockholm: International IDEA



Фернандо Касал Бертоа

Тэрээр Их Британийн Ноттингемийн Их сургуулийн Харьцуулсан улс төр судлалын дэд профессороор ажиллаж байгаа.

